# ГАРЧИГ


| № | Нэр | Хуудасны дугаар |
|---|---|---|
| 1 | Гарчиг | 1 |
| 2 | Стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн 2015 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан | 2-12 |
| 3 | Зурагт тайлан | 13-18 |
| 4 | Үндэсний хөгжлийн цогц бодлогын хэрэгжилт Хавсралт-1 | 19-20 |
| 5 | Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт Хавсралт-2 | 20-25 |
| 6 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт Хавсралт- 3 | 25-28 |
| 7 | Аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт Хавсралт-4 | 29-32 |
| 8 | Дорноговь аймгийн Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн 2015 оны “Үйлчилгээний төгөлдөршлийг нэвтрүүлэх жил”-ийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны ажлын төлөвлөгөөний биелэлт Хавсралт-5 | 33-34 |
| 9 | Үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлт Хавсралт-6 | 35-37 |
| 10 | Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ Хавсралт-7 | 38 |
| 11 | Төсвийн шууд захирагчийн манлайллын зорилтын биелэлт Хавсралт-8 | 39-41 |
| 12 | Хүний нөөцийн бодлого төлөвлөлт, хэрэгжилтийг тайлагнах хавсралт судалгаа Хавсралт-9 | 41 |

# ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН 2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015 оны 12 дугаар сарын 04 Сайншанд сум

**Хэлтсийн даргын мэдэгдэл:**

Дорноговь аймгийн Стандартчилал, хэмжил зүйн хэлтэс нь аймгийн нутаг дэвсгэрт "Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай", "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай" хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүргийнхээ хүрээнд хэмжих хэрэгсэл болон бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт, стандартыг мэдээлэх, сурталчлах, хүргэх төрийн үйлчилгээний ил тод, шуурхай, хүртээмжтэй, чанартай байдлыг хангахад төрийн албан хаагчдын хариуцлагыг өндөржүүлэх, чадваржуулах, мэргэшүүлэхэд чиглэсэн удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна.

**Нэг: Удирдлага зохион байгуулалтын талаар**

Тус хэлтэс нь Стандартчилал, хэмжилзүйн газрын даргатай бүтээгдэхүүн нийлүүлэлтийн "Үр дүнгийн гэрээ", аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Шинэ Дорноговь – 2 " хөгжлийн хөтөлбөрт 2 заалт, мөн аймгийн Засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэлтийн "Үр дүнгийн гэрээ"-г тус тус байгуулан ажиллав.

Тус хэлтэс нь Стандартчилал, техникийн зохицуулалт, бүтээгдэхүүн үйлчилгээний баталгаажуулалт, хэмжих хэрэгслийн талаар 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг гарган Стандартчилал, хэмжилзүйн газрын дарга болон аймгийн Засаг даргаар баталгаажуулан тухайн онд хэлтсийн хэмжээнд:

- **Стандартчиллыг хэрэгжүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх**
- **Хэмжилзүйн баталгаажуулалтын ажлын хүрээг өргөжүүлэх, нарийвчлалыг сайжруулах**
- **Хүний нөөцийн чадавхийг сайжруулах, мэргэшүүлэх гэсэн** үйл ажиллагааны зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Хэлтсийн 2015 онд дэвшүүлсэн зорилтынхоо хүрээнд сар бүрийн үйл ажиллагааг төлөвлөхдөө тус онд дэвшүүлсэн үндсэн зорилго, зорилтууд болон төрийн албан хаагчдын ажлын хариуцлага, хяналтыг дээшлүүлэхэд чиглэсэн уриагаа үр дүнтэй хэрэгжүүлэн, зохион байгуулж байгаа ажил арга хэмжээнд ажилтнуудын жигд оролцоог хангах, олон нийтэд чиглэсэн арга хэмжээг үр өгөөжтэй зохион байгуулахад анхааран ажиллалаа.

**Тайлангийн хугацаанд хийсэн ажлуудыг тоймлон үзэхэд:**

1. Хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, 10 төрийн албан хаагчтай үр дүнгийн гэрээ байгуулж, төрийн үйлчилгээний ажилтнуудын үйл ажиллагааны төлөвлөгөөг хянан баталсан. Тус хэлтэс нь 2014 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, үнэлгээгээрээ аймгийнхаа хэмжээнд агентлаг, албан байгууллагуудын дундаас А үнэлгээ авч, Тэргүүн байр эзэлсэн бөгөөд өнгөрөгч онд орон нутгийн төсвийн 10 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хэмжилзүйн лаборатори шинэчлэн тохижуулж, эталон тоног төхөөрөмжүүд худалдан авсан байна. Мөн олон улсын Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд үе шаттай сургалтуудыг зохион байгуулсан бөгөөд байгууллагынхаа үйл ажиллагааг олон нийтэд ил тод танилцуулж, иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлж, идэвх санаачилгатай ажилласан.
2. "Стандартчилал, хэмжил зүйн газар, орон нутгийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн", " Аймгийн нутгийн захиргааны байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн"-д хэлтсийн дарга оролцож, СХЗГ-ын дарга болон аймгийн Засаг даргатай 2015 оны үр дүнгийн гэрээ байгууллаа.
3. Байгууллагын үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлж байгаа байдалд" дүн шинжилгээ хийж, түүний мөрөөр залруулах сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэн, байнгын сайжруулалтыг хэрэгжүүлэх зорилгоор Хэмжилзүйн лаборатори, баталгаажуулалтын албаны 2015 оны

хагас жилийн үйл ажиллагааны тайланд удирдлагын дүн шинжилгээ хийж, үр дүнгээр нь төлөвлөлт, тайлагналтыг сайжруулах арга хэмжээ авсан.

4. Хэлтсийн үйл ажиллагаанд Чанарын удирдлагын тогтолцоо олон улсын стандартыг нэвтрүүлж, баталгаажуулах ажлыг хэрэгжүүлэх хүрээнд "Байгууллагын ажил үйлчилгээнд Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө"-г хэлэлцэн баталж, "ЧУТ-ны шаардлага" сургалтанд 2 ажилтнаа хамруулж, ажлын байранд стандартын бүлгүүдээр сургалт зохион байгуулав.

5. Сумдад тохирлын үнэлгээ, хэмжих хэрэгсэл баталгаажуулалтын үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх, иргэд, хэрэглэгчдийн санал хүсэлтийг сонсож, үйл ажиллагаандаа тусгах зорилгоор Сайншанд, Айраг, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ, Мандах, Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг, Эрдэнэ, Өргөн, Замын-Үүд, Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Баян тал, Шивээ говь сумын Засаг даргын тамгын газартай хамтран ажиллаж байна.

6. Аймгийн удирдах ажилтны зөвөлгөөнөөс дэвшүүлсэн төрийн байгууллагууд ажлын уялдаа холбоогоо сайжруулж, хамтран ажиллах зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд хэлтсийн зүгээс үзүүлэх төрийн үйлчилгээний шуурхай байдлыг хангах, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч, стандартчилал, хэмжилзүйн үйлчилгээг сурталчлан таниулахад чиглэсэн арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна.

7. Мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг ханган, иргэдэд хэлтсийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол хүргэх зорилгоор байгууллагын www.masm.do.gov.mn сайтыг шинээр ажилуулахад 600.0 мянган төгрөг зарцуулав. Тус сайт болон Facebook хуудас, СХЗГ болон аймгийн цахим хуудаст хэлтсийн үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг байршуулж, цаг үеийн мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллалаа. Мөн орон нутгийн "DSB", "MNT" телевизтэй хамтран ажиллаж, стандартчилал, хэмжилзүйн ажил үйлчилгээг сурталчлан таниулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгууллаа.

8. Дорноговь аймгийн Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн ажилтнууд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Стандартчилал, хэмжилзүйн байгууллагын урилгын дагуу Эрээн хотод болсон уулзалтад оролцлоо. Дэлхийн Хэмжилзүйн өдрийн хүрээнд болсон тус уулзалт арга хэмжээнд Өвөрмонголын Стандартчилал, хэмжилзүйн байгууллагын орлогч дарга Гоа Ен Жэ болон Эрээн хотын Яс чанар, техник мэргэжлийн хяналт тавих товчоон /Стандартчилал, хэмжилзүйн байгууллага/ дарга Ли Лин Хан болон холбогдох албаны хүмүүс оролцож, хоёр тал цаашид хамтран ажиллахаар тохиролцлоо. Уулзалтаар тус тусын байгууллагын үйл ажиллагааны онцлог, үүрэг чиглэлийн талаар танилцуулж, хоёр талын экспортолж буй бараа, бүтээгдэхүүний чанар, стандартыг мөрдүүлэхэд анхаарах зарим асуудлуудаар санал солилцов. Энэ үеэр Өвөрмонголын Стандартчилал, хэмжилзүйн байгууллага нь Монгол Улсын Стандартчилал, хэмжилзүйн байгууллагатай хамтран ажиллах санал, урилгыг уламжилсан байна.

9.

10. Тайлангийн хугацаанд хэлтсийн даргын А дугаартай тушаал 20, Б дугаартай тушаал 9 ыг тус тус гарган баталгаажуулж мөн 79 албан бичиг хүлээн авч шийдвэрлэн, Үүнээс хариутай бичиг 29 ирснээс 14 албан тоотод нь бичгээр хугацаанд нь хариу хүргүүлж, байгууллагаас 75 бичиг тоот төлөвлөн явуулж, 3 албан бичигт хариу ирсэн, Аймгийн Засаг даргын 13 захирамж ирснийг бүртгэж аван, захирамжийн дагуу ажиллав. Мөн 13 өргөдөл, хүсэлт ирснийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн байна.

**Хоёр. Хууль, тогтоомжийн хэрэгжилт**

Монгол улсын хууль тогтоомж, УИХ, ЗГ-ын тогтоол шийдвэр, үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд дараах ажлыг хэрэгжүүллээ. Үүнд:

Шилэн дансны тухай хууль болон "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын дагуу мэдээллийг аймгийн цахим хуудсанд сар бүр байршуулан, олон нийтэд мэдээлж байна.

Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн даргын 2015 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн А/03 тоот тушаалын дагуу байгууллага дээр**" Угтах үйлчилгээ** "-г нэвтрүүлэн, үйлчилгээний журмыг батлаж, хуваарь гарган ажиллаж байна.

Авлигатай тэмцэх газарт хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан хаагчдын жагсаалтад орсон төрийн захиргааны ТЗ-5 ангилалд хамаарах **6** албан хаагч ХАСХОМ гаргахгүй болсон өөрчлөлтийн дагуу ТЗ-6-аас дээшхи ангилалд хамаарах **1** албан хаагч хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд нь цахимаар гаргаж өгсөн.

"Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хууль"-ийн хүрээнд худалдаа үйлчилгээний аж ахуй нэгжид тохирлын үнэлгээ хийж, **287** аж ахуй нэгжид тохирлын гэрчилгээ олгосон.

Монгол Улсын ЗГ-ын 143-р тогтоолын хэрэгжилтийг хангаж, Баталгаажуулалтын албаны мэдээллийн самбарыг шинэчлэн, байршуулсан. Мөн байгууллагын мэдээллийн самбар, төсөв санхүүгийн мэдээллийн самбарын мэдээллийг шаардлагатай тухай бүр шинэчлэж байна.

ЗГ-ын 2015 оны 03 сарын 09-ны өдрийн 82 тоот тогтоолын дагуу зуны цагийн хувиараас өвлийн цагийн тоололд шилжин ажил үйлчилгээг эхлэх цагийн хуваарийг хэвээр мөрдөн ажиллалаа.

Архивын тухай хуулийн дагуу байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд:

- Байгууллагын Баримт бичиг нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулж, ББНШК-ын дүрмийг боловсруулан батлав.
- Байгууллагын архивын баримтанд тооллого хийж, баримтын тооллогын хуудас, баримтын тооллогын актыг тус тус үйлдэв.
- Байгууллагын 1989-2013 оны байнга, түр, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж бүхий баримтуудыг хамруулан тоололго хийв.
- Байгууллагын архивын дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн архивын өрөө, хадгаламжийн санд галын аюулгүй байдлын дүгнэлтийг гаргуулсан байна.
- Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын урьдчилсан үзлэгээр Аймгийн ЗДТГ-аас 4 хүний бүрэлдэхүүнтэй комисс ирж шалган, улсын үзлэгийн нэгдсэн дүнгээр 80.7 буюу "В"
- Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн ажлын зохион байгуулалтыг сайжруулах үүднээс "Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам", "Байгууллагын тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх, хадгалах, хүлээлцэх журам"-уудыг тус тус шинээр боловсруулан гаргаж, батлуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байна. Мөн "Байгууллагын мэдээллийн технологийн тоног төхөөрөмж ашиглах журам"-ыг шинээр боловсруулан гаргаж, батлуулан ажиллав.
- Байгууллагын албан хаагчдад Аймгийн Архивын тасгийн дарга, улсын байцаагч Ч. Чулуунцэцгийг урьж "Архив, албан хэрэг хөтлөлт"-сэдвээр мэдлэг олгох сургалтыг 2015 оны 02 дугаар сарын 04-ны өдөр зохион байгуулсан.

2015 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс авсан санал асуулгаар анхаарал татсан асуудлын нэг бол Сайхандулаан сумд байрлах "Илчит нутаг" ХХК-ийн ШТС-ын шатахуун түгээгүүрт иргэд итгэлгүй байгаа гомдол, санал гарч байгаа тул тухайн үйлчилгээнд ашиглагдаж байгаа түгээгүүрт хамтарсан хяналт шалгалт явуулж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор 2015 оны 09 сарын 14-ны өдөр улсын шалгагч нар, МХГ-ын Хэмжилзүйн улсын байцаагчтай хамтран шалгалт хийлээ. Шалгалтаар түгээгүүрээ цаг тухайд нь бүрэн баталгаажуулалтад хамруулаагүй зөрчил илэрснийг арилгах арга хэмжээ авлаа.

**Салбарын тушаал шийдвэр, СХЗГ-ын даргын тушаалын хэрэгжилт:**

Хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөр хураамжид "Хэмжил зүйн ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 11 дугаар сарын 06-ны өдрийн 117 тоот тушаалыг баримтлан ажилласан.

СХЗГ-ын даргын 2015 оны 03 сарын 13-ний өдрийн А/64 дугаар тушаалаар баталсан "Стандартыг түгээх гэрээт ажил үйлчилгээний төлбөрийн жишиг хэмжээ"-г мөрдөн ажиллаж, **40** аж ахуй нэгж, байгууллага иргэнд **10** нэрийн **254** стандартаар хангах үйлчилгээ үзүүлсэн.

СХЗГ-ын даргын 2013 оны А/23 тоот тушаалаар баталсан "Орон нутгийн стандартчилал, хэмжил зүйн хэлтсийн мэдээ, тайлан, боловсруулах, илгээх, журам"-ыг хэрэгжүүлж, 4 чиглэлээр мэдээ, тайланг заасан хугацаанд хүргүүлж байна.

2014 оны А/287 тоот тушаалаар баталсан "Хяналт шинжилгээ, үнэлгээний журам"-ын дагуу байгууллагын 2015 оны 1-р улирлал, эхний хагас жил, 3-р улирлын үйл ажиллагааны тайланд хяналт шинжилгээ хийж, заасан хугацаанд тайлагнасан.

2015 оны 02 дугаар 03

**Гурав. Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалт**

Хэлтсийн төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээний биелэлт, төрийн үйлчилгээний ажилтнуудын 2015 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэхэд 2 ажилтан А үнэлгээ, 4 ажилтан В үнэлгээ авч, төрийн үйлчилгээний 4 ажилтан хариуцсан ажил үүргээ сайн биелүүлсэн байна.

Хүний нөөцийг хөгжүүлэх зорилгоор ажилтнуудын мэдлэг чадварыг дээшлүүлэх, бие даан суралцах боломжийг бүрдүүлж зорилтот сургалтанд хамруулахаас гадна дотооддоо хууль эрхзүйн болон мэдлэг мэргэшлийн дээшлүүлэх, эрүүл, зөв амьдралын хэвшлийг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт мэдээллийг хийж байна.

Хэлтсийн төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, шилжилт хөдөлгөөн, хүний нөөцийн бүрэлдэхүүний талаарх дэлгэрэнгүй тайлан мэдээг гаргаж, заасан хугацаанд СХЗГ болон аймгийн ЗДТГ-т хүргүүлсэн.

**Дөрөв. Төсөв санхүүгийн үйл ажиллагаа / 2015 оны 11 сарын 30-ны байдлаар /**

- Тус хэлтэс нь 2015 онд 107129,9 мянган төгрөгийн төсөвт үйл ажиллагаа төлөвлөгдсөнөөс 105730.8 мянган төгрөгийн санхүүжилт авч 103335.4 мянган төгрөгийн зарлага гаргаж ажилласан ба 31510,0 мянган төгрөгийн өөрийн орлого төлөвлөгдсөнөөс 57157,8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэв.Үүнээс өмнөх оны авлага 2061.0 мян.төг барагдсан байна. Улсын төсөвт төвлөрүүлэх өөрийн орлогын төлөвлөгөөг 174 %-иар биелүүлсэн байна.

Одоогийн байдлаар байгууллагын хэмжээнд бусдад төлөх өглөг **3388,4** мянган төгрөг, **1192,1** мянган төгрөгийн авлагатай байна.

- Хэлтсийн ажилтнууд 2015 оны жилийн эцсийн байдлаар албан томилолтоор давхардсан тоогоор 38 óäàà 117 õîíîã àæèëëàñàí áàéíà. ¯¿íýýñ Улаанбаатар хотод 32 хоноã, сургалтаар 2 õîíîã, õөдөө орон нутаг руу 117 хоног явж ажиллав.

Томилолтын зардалд **5793,3** мянган төгрөг төлөвлөгдсөнөөс **3799,5** мянган төгрөгийн санхүүжилт авч 3799,5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

***<u>Орлогын төлөвлөгөөг үйл ажиллагааны төрөл тус бүрээр нь хүснэгтээр харуулбал:</u>***

| № | Баталгаажуулалтын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөөний биелэлтийг хувиар харуулбал |
|---|---|---|---|---|
| 1 | Тохирлын үнэлгээ | 8200.0 | 11697,9 | 142,6 |
| 2 | Цулын хэмжлийн баталгаажуулалт | 8250.0 | 11024,0 | 133,6 |
| 3 | Цахилгааны хэмжлийн баталгаажуулалт | 8500.0 | 18327,9 | 215,6 |
| 4 | Эзлэхүүн хэмжлийн баталгаажуулалт | 5500.0 | 11842,0 | 215,3 |
| 5 | Стандартын салбар сан | 460.0 | 1869,3 | 406,4 |
| 6 | Даралтын хэмжлийн баталгаажуулалт | 600.0 | 335,7 | 56,0 |

| | | | |
|---|---|---|---|
| **Нийт дүн** | **31510.0** | **55096,8** | **174,9** |

***Орлогын төлөвлөгөөг үйл ажиллагааны төрөл тус бүрээр нь графикаар харуулбал:***




**Тав. Үндсэн үйл ажиллагааны талаар**

Дорноговь аймгийн Сайншанд, Замын-Үүд, Сайхандулаан, Айраг, Мандах, Хатанбулаг, Улаанбадрах, Даланжаргалан, Иххэт, Дэлгэрэх, Алтанширээ, Хөвсгөл,Эрдэнэ, Өргөн, Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Баянтал, Шивээ говь, сумдад ээлжит баталгаажуулалтаар ажиллаж бүтээгдэхүүн, үйлчилгээ болон хэмжилзүйн баталгаажуулалтын ажлыг хэрэгжүүллээ.

Баталгаажуулалтын ажлыг итгэмжлэгдсэн эрх бүхий лабораторитой гэрээ байгуулан сорилтын үр дүнг ашиглан îðîí íóòàãò ¿éëäâýðëýæ áàéãàà õ¿íñíèé á¿òýýãäýõ¿¿íä тохирлын үнэлгээ õèéæ ä¿ãíýëò ãàðãàí áàòàëãààæóóëæ байна.

Шударга ёс, ил тод байдлыг эрхэмлэн иргэдэд хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэх зорилгоор Баталгаажуулалтын салбар зөвлөлийг сум бүрт байгуулан хуралдаж, тохирлын гэрчилгээг газар дээр нь олгон, ард иргэдэд түргэн шуурхай үйлчилж байна. Энэ онд баталгаажуулалтын салбар зөвлөл 46 удаа хуралдаж, нийт 287 тохирлын гэрчилгээ олгохоор шийдвэрлэсэн байна.

***Тохирлын үнэлгээнд хамрагдсан бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар:***

***Баталгаажуулалтанд хамрагдсан үйлчилгээг төрөл тус бүрийг хүснэгтээр авч үзвэл:***

| № | Үйлчилгээний нэр | Хэмжих нэгж | Аж ахуйн, нэгжийн тоо |
|---|---|---|---|
| **1** | Хүнсний дэлгүүр | ш | 100 |
| **2** | Баар караоке | ш | 8 |
| **3** | Дэн буудал | ш | 6 |
| **4** | Гуанз | ш | 7 |
| **5** | Ресторан | ш | 15 |
| **6** | Зочид буудал | ш | 6 |
| **7** | ШТС | ш | 5 |
| **8** | Хүнсний мухлаг | ш | 65 |
| **9** | Кафе | ш | 4 |
| **10** | Жуулчны бааз | ш | 3 |
| **11** | Интернэт кафе | ш | 3 |

| | | | |
|---|---|---|---|
| **12** | Биллъярдын үйлчилгээ | ш | 1 |
| **14** | Худалдааны төв | ш | 4 |
| **15** | Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ | ш | 1 |
| **16** | Халуун ус | ш | 1 |
| | Нийт | | **229** |

***Баталгаажуулалтанд хамрагдсан дотоодын бүтээгдэхүүнийг төрөл тус бүрийг хүснэгтээр авч үзвэл:***

| № | Бүтээгдэхүүний нэр | Хэмжих нэгж | Аж ахуйн, нэгжийн тоо |
|---|---|---|---|
| **1** | Хэрчсэн гурил | ш | 3 |
| **2** | Вакум цонх | ш | 1 |
| **3** | Бууз, банш | ш | 4 |
| **4** | Талх, талхан бүтээгдэхүүн | ш | 13 |
| **5** | Цэвэржүүлсэн ус | ш | 2 |
| **6** | Зайдас | ш | 1 |
| **7** | Загсгал цай | ш | 1 |
| **8** | Ноос | ш | 1 |
| **9** | Нүүрс | ш | 1 |
| **10** | Хиам | ш | 1 |
| | Нийт | | **28** |

***3.3 Экспортын бүтээгдэхүүн***

| № | Бүтээгдэхүүний нэр | Хэмжих нэгж | Аж ахуйн, нэгжийн тоо |
|---|---|---|---|
| **1** | Нүүрс | ш | 1 |
| **2** | Мөнгөний хүдэр | ш | 1 |
| | Нийт | ш | **6 / давхардсан тоогоор /** |

**Стандартын салбар сангийн үйл ажиллагаа**

Стандартын мэдээллийн салбар сангаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэний захиалгын дагуу 40 аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн стандартын захиалгыг үндэслэн 10 нэрийн 254 стандартын борлуулалт хийж арга зүйн зөвлөгөө өгсөн.

Шинэчлэгдсэн болон шинээр батлагдсан стандартын талаар мэдээллийг тухай бүрт нь байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулан, хамтран ажиллагч байгууллагуудын холбогдох ажилтнуудад цахим хэлбэрээр хүргэн, мэдээллээр хангасан.

Аймгийн ХХААГ-ын хүнсний мэргэжилтэн, Хөдөлмөрийн хэлтсийн ЖДҮГ-ын мэргэжилтнээр дамжуулан сумдад үйлдвэрлэж байгаа хүнсний үйлдвэр, цехийн бүтээгдэхүүний хаяг шошгыг холбогдох стандартын шаардлагад нийцүүлэх талаар манай байгууллагаас зөвлөгөө авах, стандартаар хангагдах шаардлагатай байгаа талаар болон Сайншанд сумын нийт үйлдвэрлэл эрхлэгчдэд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийхээ хаяг шошгонд "Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтонд тавих шаардлага MNS CAC 1:2007" стандартын шаардлагыг заавал мөрдөж ажиллахыг тогтмол зөвлөн ажиллаж байна.

**Хэмжил зүйн ажил, үйлчилгээ**

Хэмжилзүйн лаборатори нь худалдаа үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, үйлдвэр, аж ахуй нэгж болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзэмшилд ашиглагдаж байгаа жин хэмжүүр, туухай, цахилгаан болон усны тоолуур, шатахуун түгээгүүр, даралтын хэмжих хэрэгсэл зэргийг баталгаажуулж, хэмжлийн үнэн зөв нэгдмэл байдлыг хангахад үндсэн үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

**Хэмжилзүйн лаборатори :**

Монгол Улсын Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн дагуу орон нутаг дахь хэмжил зүйн хяналтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Стандартчилал, хэмжилзүйн зөвлөлийн 2013 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/19дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу хэмжих хэрэгслийн төрөл бүрээр баталгаажуулалт хийсэн.

***Нийт /Дорноговь, Говьсүмбэр аймгийн хэмжээнд/ хэмжих хэрэгслийг баталгаажуулалтын төрлөөр нь багцалж хүснэгтээр харуулбал/***

| *№* | ***Хэмжлийн төрөл*** | ***Аж ахуй нэгжийн*** | ***Иргэд*** | ***Төлөвлөгөө /хэмжих хэрэгслийн тоо/*** | ***Гүйцэтгэл /хэмжих хэрэгслийн тоо /*** | ***Гүйцэтгэлийн дүнг төлөвлөгөөтэй харьцуулан хувиар дүгнэвэл*** |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цахилгаан хэмжил | 800 | 2431 | 2000 | 3231 | 129,2 % |
| 2 | Цул хэмжил | 420 | 412 | 940 | 1050 | 111 % |
| 3 | Эзлэхүүн хэмжил | 28 | 2 | 450 | 644 | 143% |
| 4 | Даралт | 8 | - | 120 | 68 | 56% |
| | | | | Нийт 1283 ширхэг хэмжих хэрэгсэл баталгаажуулсан байна | | |

***Дээрх хүснэгтийг графикаар үзүүлвэл:***




Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах ажил, үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр арга хэмжээг авч цахилгаан тоолуур, хий шингэний эзэлхүүн, цулын, даралтын зэрэг 9 төрлийн хэмжих хэрэгслийн чиглэлээр аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нийт **1283** хэмжих хэрэгслийг хамруулж улсын баталгаажуулалт хийв.

***Үүнээс задалж хэмжих хэрэгслийн чиглэлээр танилцуулбал:***

***Цахилгаан хэмжих хэрэгслийн баталгаажуулалт:***

Сайншанд төмөр замын Эрчим хүч, ус хангамжийн 2-р анги, ÁÇªÁÖÒÑ ÒªÕÊ-èéí, Äîðíîãîâü аймгийн ЦТСС- ын цахилгаан тоолуурын лабораторитой хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний үндсэн дээр 1 ба 3 фазын 3231 ширхэг Цахилгаан тоолуур тулсын баталгаажуулалтад хамруулсан байна.

***Нийт /Дорноговь аймгийн хэмжээнд ээлжит баталгаажуулалт/ хэмжих хэрэгслийг баталгаажуулалтын төрлөөр нь багцалж хүснэгтээрхаруулбал:***

| № | Хэмжих хэрэгслийн төрөл | Дорноговь аймаг | Говьсүмбэр аймаг |
|---|---|---|---|
| **1** | 1 фазын механик тоолуур | 782 | - |
| **2** | 1 фазын цахилгаан механик тоолуур | 1980 | - |
| **3** | 1 фазын электрон тоолуур | 100 | - |
| **4** | 3 фазын механик тоолуур | 27 | - |
| **5** | 3 фазын цахилгаан механик тоолуур | 338 | - |
| **6** | 3 фазын электрон тоолуур | 1 | - |
| **7** | 100 вольтын электрон тоолуур | 2 | - |
| **8** | 100 вольтын цахилгаан механик тоолуур | 1 | |
| ***Нийт дүн*** | | ***3231*** | - |

Цахилгаан хэмжүүрийн төрлөөр хэмжих хэрэгслийг шалгах ажиллагааг Төмөр замын ЭХУХ-ийн 2-р анги болон Дорноговь аймгийн ЦТСС-ны цахилгаан тоолуур засварлан тохируулах лабораторитой хамтран үйл ажиллагаанд хяналт тавьж, зохих стандартын дагуу баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэж байна.

***Хий, шингэний хэмжих хэрэгслийн баталгаажуулалт:***

2015 оны жилийн эцсийн байдлаар õèé øèíãýíèé õýìæèõ õýðýãñýë íèéò 644 øèðõýãèéã áàòàëãààæóóëñàí.

Аймгийн Нефть хангамжийн салбаруудтай байгуулсан гэрээний үндсэн дээр график, төлөвлөлтийн дагуу мөн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Шатахуун түгээгүүрийн станцуудын хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт олголоо.

Үүнд:

Шатахуун түгээгүүр 408, автоцистерн 92, шингэний тоолуур 3, ажлын мерник 5, туузан метр 4, сүмбэн метр 2, денситиметр 12, усны тоолуур 118 ширхэгийг тус тус ээлжит баталгаажуулалт хийсэн байна.

***Нийт /Дорноговь, Говьсүмбэр аймгийн хэмжээнд ээлжит баталгаажуулалт / хэмжих хэрэгслийг баталгаажуулалтын төрлөөр нь багцалж хүснэгтээр харуулбал:***

| № | Хэмжих хэрэгслийн төрөл | Дорноговь аймаг | Говьсүмбэр аймаг |
|---|---|---|---|
| **1** | Шатахуун түгээгүүр | 309 | 99 |
| **2** | Автоцистерн | 42 | 50 |
| **3** | Шингэний тоолуур | 3 | - |
| **4** | Туузан метр | 4 | - |
| **5** | Денситиметр | - | 12 |
| **6** | Тосны хэмжүүр | - | - |
| **7** | Усны тоолуур | 118 | - |
| **8** | Шилэн хэмжүүр | - | - |
| **9** | Ажлын мерник | 4 | 1 |
| **10** | Сүмбэн метр | 2 | - |
| Нийт дүн | | **644** | **-** |

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр Дорноговь аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа “Магнай трейд” ХХК, “Шунхлай” ХХК, “НИК” ХК, “Сод Монгол” ХХК, Улаанбаатар төмөр замын ЭХУХ-ийн 2-р анги бусад 14 аж ахуй нэгжтэй хамтран үйл ажиллагаанд нь хяналт тавьж, зохих стандартын дагуу баталгаажуулалтын ажлыг хийж гүйцэтгэж байна

***Цул, механик хэмжих хэрэгслийн баталгаажуулалт:***

Дорноговь аймгийн нутаг дэвсгэр дээр худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй 412 аж ахуйн нэгж, байгууллага 420 хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзэмшилд ашиглагдаж байгаа нийт 1050 ш хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалтад хамрууллаа.

***Баталгаажуулалтанд хамрагдсан төрөл тус бүрийг хүснэгтээр авч үзвэл:***

| № | Хэмжих хэрэгслийн төрөл | Дорноговь аймаг | Говьсүмбэр аймаг |
|---|---|---|---|
| **1** | ВНЦ-10 жин | 41 | 16 |
| **2** | Эмнэлгийн жин | 40 | 20 |
| **3** | ACS 15-30 жин | 682 | 127 |
| **4** | РП50-500 | 21 | 2 |
| **5** | TCS-100-300 жин | 41 | 14 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | | - | - |
| 7 | Бусад төрлийн жин | 26 | 4 |
| 8 | Их даацын жин | 13 | 3 |
| ДҮН | | **864** | **186** |

***Даралтын хэмжих хэрэгслийн баталгаажуулалт:***

Дорноговь аймгийн "Чандмань- Илч" ОНӨ ХХК , Улаанбаатар төмөр замын Барилга орон сууц үйлчилгээний газар, Говьсүмбэр аймгийн ОНӨ-УСДУ-ХХК зэрэг аж ахуйн, нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

8 аж ахуй нэгж, байгууллагын 68 ширхэг даралтын хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт олголоо. Үүнд:

Цахилгаан контакттай манометр 4 ш, техникийн манометр 61 ш, автоклавны манометр 3 ширхэг тус тус баталгаажуулсан байна.

***Нийт /Дорноговь аймгийн хэмжээнд ээлжит баталгаажуулалт / хэмжих хэрэгслийг баталгаажуулалтын төрлөөр нь багцалж хүснэгтээр харуулбал:***

| № | Хэмжих хэрэгслийн төрөл | Дорноговь аймаг | Говьсүмбэр аймаг |
|---|---|---|---|
| 1 | Цахилгаан контактай манометр | **4** | **-** |
| 2 | Техникийн манометр | **61** | **-** |
| 3 | Автоклавны манометр | **3** | **-** |
| | **Нийт** | **68** | **-** |

**Зургаа. Сургалт сурталчилгаа**

1. Тус хэлтэс нь "Баталгаажуулалт ба Стандартчиллын зүй тогтол" сэдэвт сургалтыг Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газартай хамтран зохион байгууллаа. Сургалтанд тус аймгийн бизнес эрхлэгч аж ахуй нэгж, байгууллага, иргэд оролцсон байна. Тус сургалтаар Баталгаажуулалтын шинжээч Х.Оюу-Эрдэнэ, Стандартын салбар сан хариуцсан мэргэжилтэн П.Энх-Отгон нар Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт болон Монгол Улсад мөрдөж байгаа стандартын талаар мөн Улсын шалгагч А.Мөнх-Эрдэнэ, Э. Мөнх-Эрдэнэ нар "Хэмжил зүй бидний амьдралд" сэдвээр хэмжилзүйн хяналтын Улсын байцаагч О. Долгион "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах хууль тогтоомж" сэдвээр тус тус мэдээлэл өглөө.

2. Дэлхийн хэмжилзүйн өдрийг угтсан арга хэмжээнийхээ хүрээнд Стандартчилал, хэмжил зүйн газрын Хэмжилзүйн бодлого, эталоны газартай хамтран тавдугаар сарын 02-ны өдөр нээлттэй хэлэлцүүлэг, мэдээлэл солилцох уулзалтыг Сайншанд хотод зохион байгууллаа. Уг арга хэмжээнд Хэмжилзүйн бодлого, эталоны газрын дарга З.Ганболд, Цахилгаан эталоны лабораторийн ахлах мэргэжилтэн Б.Итгэл болон бусад холбогдох мэргэжилтнүүд оролцож, удахгүй УИХ-аар хэлэлцүүлэх "Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцуулан, төрөөс хэмжилзүйн талаар баримталж буй бодлого, үйл ажиллагааны сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг хүргэж, уулзалтад оролцогчдын асуултад хариулан, санал хүсэлтийг нь сонссон байна.Тус уулзалтанд аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтэс, Цахилгаан түгээх сүлжээ, Улаанбаатар төмөр замын Эрчим хүч, ус хангамжийн хоёрдугаар анги, "Чандмань Илч"

ТӨХХК, "Шунхлай говь" ХХК, "Сод Монгол Групп" ХХК зэрэг аж ахуй нэгж, байгууллагуудын ажилтан, инженерүүд оролцон өөрсдийн байгууллагын үйл ажиллагаа, хэмжилзүйн ажил, үйлчилгээ явуулахад тулгарч буй бэрхшээл, тулгамдаж байгаа асуудлуудыг хөндөн ярилцаж, санал бодлоо чөлөөтэй солилцсон юм.

3. Дорноговь аймгийн худалдагч нарын анхдугаар зөвлөгөөнийг 2015 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр аймгийн ЗДТГ болон Стандартчилал, хэмжилзүйн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Монголын Худалдагч нарын холбоо хамтран зохион байгууллаа. Зөвлөгөөнд оролцогчдод хэлтсийн дарга Ш.Энхбаяр мэндчилгээ дэвшүүлж, Баталгаажуулалтын шинжээч Х.Оюу-Эрдэнэ, Г.Шинэчимэг нар худалдааны стандарт болон байгууллагын үйл ажиллагааныхаа талаар танилцуулга, мэдээллийг хүргэсэн байна. Монголын Худалдагч нарын холбоо нь тус аймагт салбар зөвлөлөө байгуулан, сумдад худалдагч нарын сургалт зохион байгуулан идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлжээ.

4. Иргэдийн эрдэс баялагийн салбарын тухай мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, оролцоог нэмэгдүүлэх, бүсийн түвшинд туршлага солилцох, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилготой олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын өмнөд бүсийн чуулган 2015 оны есдүгээр сарын 11-ний өдөр Сайншанд хотод боллоо. Чуулганд төр, иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлөөлөл 150 гаруй хүн оролцсон бөгөөд Стандартчилал, хэмжилзүйн газрын Сорьцын хяналтын улсын байцаагч Ч.Бямбасүрэн, Дорноговь аймгийн Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн дарга Ш.Энхбаяр нар оролцож үнэт эдлэл баталгаажуулалт, сорьцын хяналтын талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааныхаа талаар танилцуулсан байна.

5. Стандартчилал, хэмжилзүйн газрын Сорьцын хяналтын улсын байцаагч, эрдэнийн чулууны шинжээч Ч.Бямбасүрэн, Дорноговь аймгийн Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн дарга Ш.Энхбаяр нар Сайншанд суманд гоёл чимэглэлийн чулуугаар бэлэг дурсгал, үнэт эдлэлийн үйлдвэрлэл эрхэлдэг иргэд, нөхөрлөлийн үйл ажиллагаатай танилцлаа. Энэ үеэр үйлдвэрлэл эрхлэгчдэд холбогдох хууль, дүрмийн талаар танилцуулан, тулгарч буй асуудал, санал хүсэлтийг нь сонсож, зөвлөмж, мэдээлэл өгч ажилласан байна.

6. Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдийн дунд "Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал" сэдвээр уулзалт, ярилцлагыг зохион байгууллаа. Уулзалтанд Хамарын хийдэд бизнес эрхэлдэг иргэд болон зочид буудал, жуулчны баазын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж,байгууллага, иргэд оролцсон байна. Тус уулзалтанд Баталгаажуулалтын шинжээч Х. Оюу-Эрдэнэ, Стандартын салбар сан хариуцсан мэргэжилтэн П. Энх-Отгон нар Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт болон Монгол Улсад даган мөрдөж байгаа стандартын талаар мэдээлэл өглөө.

7. Аймгийн хэмжээнд жил бүр зохион байгуулдаг "Дорноговь түншлэл-2015" намрын үзэсгэлэн худалдаа 2015 оны 9 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд "Цэлмэг тэнгэр" худалдааны төвд боллоо. Стандартчилал, хэмжилзүйн хэлтэсээс хамтран зохион байгуулсан үзэсгэлэн худалдаанд аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, иргэд өргөнөөр оролцож, шилдэг бүтээгдэхүүн үйлчилгээг амжилттай шалгаруулсан байна. Аймгийн шилдэг Зочид буудлын үйлчилгээгээр шалгарсан "Хур говь" ХХК-ийн менежер Б.Батбаярт Стандартчилал хэмжилзүйн хэлтсийн нэрэмжит цом, өргөмжлөл, мөнгөн шагналыг гардуулан өглөө.

8. Дэлхийн Чанарын өдрийг угтсан арга хэмжээний хүрээнд Замын- Үүд сумын ЗДТГазартай хамтран тус сумын бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэж байгаа хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгыг стандартын шаардлагад нийцүүлэх зорилготой сургалтыг 2015 оны 11 дүгээр сарын 11- нд зохион байгуулав. Тус сургалтанд нийт 30 гаруй аж ахуйн нэгж, хувиараа эрхлэгч нар хамрагдсан бөгөөд Хаяг шошгоны стандарт, Бүтээгдэхүүн баталгаажуулалты талаар тус хэлтсийн баталгаажуулалтын шинжээч Х. Оюу - Эрдэнэ, Г. Шинэчимэг, Улсын шалгагч П. Энх- Отгон Хэмжилзүйн баталгаажуулалтын талаар тус тус мэдээлэл хийж, хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан аюулгүй цэвэр хүнс, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хангахад бизнес эрхлэгчдэд мэдлэг олголоо.

**Зорилтот сургалтанд** ажилтнуудаа хамруулан мэдлэг чадварыг дээшлүүлэхэд анхааран ажиллалаа. Үүнд:

- СХЗГ-т зохион байгуулсан “ЧУТ. Үндсэн шаардлага” сургалтанд хэлтсийн 2 ажилтан хамрагдаж, ЧУТ олон улсын стандарт, түүнийг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхийн ач холбогдлийн талаар мэдээлэл авлаа.
- Цахилгаан хэмжүүрийн улсын шалгагч П.Энх-Отгон нь Европын холбооны төслийн хүрээнд Туркийн Итгэмжлэлийн байгууллагаас 2015 оны 5 дугаар 14-15 өдрүүдэд зохион байгуулсан **ISO/IEC 17025** стандартын дагуу дотоод аудит хийх 16 цагийн сургалтанд амжилттай хамрагдаж сертификат авлаа.
- ХБНГУ-ын “Landis-Gyr” фирмийн Монгол Улс дахь албан ёсны дистрибьютер “Ультрасоник” ХХК нь “Дулааны эрчим хүчний хэмнэлт ба Хэмжүүржүүлэлт” сэдэвт сургалт зохион байгуулж тус сургалтанд Эзлэхүүн, даралтын Улсын шалгагч Э.Мөнх-Эрдэнэ хамрагдлаа.

**Долоо. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах талаар:**

Хэрэглэгч, үйлчлүүлэгчээс гаргасан гомдол саналын дагуу аймгийн МХГ-тай хамтран Сайхандулаан сумд байрлах “Илчит нутаг” ХХК, Сайншанд сумын 5-р багт үйл ажиллагаа явуулдаг “Цэцэрлэг баян торх” ХХК-ийн ШТС-ын шатахуун түгээгүүрт хамтарсан хяналт шалгалт явуулж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авлаа.

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилт, 2014 онд хэмжилзүйн ажил үйлчилгээг сайжруулах зорилгоор холбогдох байгууллагуудад хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, байгууллагын хэмжилзүйн дотоод хяналтын алба байгуулах шаардлагатай талаар зөвөлгөө өглөө.

Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийн холбогдох мэргэжилтнүүдэд шинэчлэгдсэн болон шинээр батлагдсан стандартын талаарх мэдээллийг цахим хэлбэрээр хүргүүлсэн.

**Найм. Санал хүсэлтийн шийдвэрлэлтийн байдал:**

Жилийн эцсийн байдлаар бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтаар Говьсүмбэр аймаг, Замын-Үүд, Даланжаргалан,Эрдэнэ, Айраг сумын Засаг даргын тамгын газрын хүсэлтээр 25 аж ахуй нэгжид баталгаажуулалт хийв. Мөн Айраг суманд “Хэрлэн импекс” ХХК-ий жонш баяжуулах уурхайн ШТС болон автопүүг, “Их говь Энержи” компанийн автопүү баталгаажуулсан.

## Дорноговь аймгийн Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн зурагт тайлан

*Дорноговь аймгийн Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийнхэн 2014 оны ажлын үр дүн, үнэлгээгээрээ аймгийнхаа хэмжээнд агентлаг, албан байгууллагуудын дундаас А үнэлгээ авч, Тэргүүн байр эзэлсэн бөгөөд шагналыг сар шинийн босгон дээр аймгийн удирдлагууд гардуулж, амжилт хүслээ.*




*Дорноговь аймгийн Засаг даргын орлогч Б.Төмөрхуяг манай хэлтсийн үйл ажиллагаатай танилцан, ажилтнуудын санал хүсэлтийг сонслоо.*






СТАНДАРТЫН МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ





*Улсын шалгагч нар баталгаажуулалтын ажилд өмсөх шинэ ажлын хувцастай боллоо.*





ГОВЬСҮМБЭР АЙМАГТ “Баталгаажуулалт ба Стандартчиллын зүй тогтол” СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА






*Бүтээгдэхүүн, үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтыг хэрэгжүүллээ.*





НЭЭЛТТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА





ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ УУЛЗАЛТАД ОРОЛЦОВ









СОРЬЦЫН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭВ



УУЛ УУРХАЙН ЧУУЛГАНД ОРОЛЦЛОО





ХУДАЛДАГЧ НАРЫН ЗӨВЛӨГӨӨН ЗОХИОН БАЙГУУЛАВ







ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДАА БОЛЛОО






АЙМГИЙН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ЗӨВЛӨЛ 49 УДАА ХУРАЛДЛАА.



.

ХАЯГ ШОШГО, САВ БАГЛАА БООДЛЫН СТАНДАРТЫН ШААРДЛАГА СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА.









**(2015 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүн)**

| 1 | Үзүүлэлт | Өмнөх Он /мян. Төг / | Тайлантон | Өөрчлөлт | Үнэлгээ | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хувь | Оноо |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1. | Төсвийн орлогын гүйцэтгэлийн хувь Үүнээс: | **100485.1** | | | | |
| | Хэмжүүр баталгаажуулалт | **49244.9** | **41529,6** | | | |
| | Чанарын баталгаажуулалт | **12033.9** | **11697.9** | | | |
| | Стандартын сан | **1514.9** | **1869.3** | | | |
| | Бусад | **-** | **-** | | | |
| 2. | Төсвийн зарлагын гүйцэтгэлийн хувь | | | | | |
| 3. | Байгууллагын өр (мян.төг) | **3167.9** | **3388,4** | | | |
| 4. | Нийт хөрөнгө оруулалт (мян.төг) | **10000.0** | | | | |
| 5. | Хэлтсийн дэвшүүлсэн зорилтууд нь үйл ажиллагааны хэтийн бодлого, төлөвлөгөөтэй нягт уялдсан байдал | | | **-** | | |
| 6. | Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөрт стандартчилал, хэмжилзүйн чиглэлээр тусгуулсан зорилтын тоо | **2** | **2** | | | |
| 7. | Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн эрхлэх үндсэн үйл ажиллагааны эрх зүйн орчинг бүрдүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр боловсруулсан дүрэм, журмын тоо, | **3** | | | | |
| 8. | Эрхлэн явуулах үйл ажиллагааны чиглэлээр итгэмжлэлд хамрагдсан байдал | Итгэмжлэл ийн хугацаа дуссан | Итгэмжлэл ийн хугацаа дуссан | | | |
| 9. | Баталгаажуулалтад хамрагдсан хэмжих хэрэгслийн нийт тоо, Үүнээс: | 8093 | 4993 | -3100 | | |
| 10. | - механик | 1110 | 1050 | -60 | | |
| 11. | - цахилгаан | 6262 | 3231 | -3031 | | |
| 12. | - ээзлхүүн багтаамж | 575 | 644 | +69 | | |
| 13. | - даралт | 146 | 68 | -78 | | |
| 14. | Баталгаажуулсан ажлын эталоны тоо | 9 | 14 | +5 | | |
| 15. | Дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний чанарын баталгаажуулалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллага, бүтээгдэхүүний тоо | 15 | 28 | 13 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 16. | Баталгаажуулалтад хамрагдсан үйлчилгээний нэр төрөл (давхардсан тоогоор) | 234 | 229 | -5 | | |
| 17. | Баталгаажуулалтад хамрагдсан экспортын бүтээгдэхүүн, аж ахуйн нэгжийн тоо | 10 | | | | |
| 18. | Сургалт, мэдээлэл, сурталчилгаа, түүнд хамрагдсан хүний тоо | 7 | 2 | **-5** | | |
| 19. | Хүний нөөцийн удирдлагын чиглэлээр авч хэрэгжүүлсэн зорилтын биелэлт | 3 | 3 | **-** | | |
| 20. | Үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ | 100 | 100 | | | |
| 21. | Хэлтсийн даргаас Ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт | | | | | |
| 22. | Аймгийн Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, Засаг даргаас өгсөн үнэлгээ | **A** | | | | |
| 23. | Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр гаргасан шинэ санаа, санаачлага түүний үр дүн | 100% | 100% | | | |
| 24. | Тайлан, мэдээ, хугацаатай албан бичгийн хариу явуулсан байдал | 100% | 100% | | | |
| 25. | Хэрэглэгчийн үнэлгээ | **-** | 80% | | | |
| 26. | СХЗГ-аас өгсөн үүрэг, даалгавар, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байдал | 100% | 100% | | | |
| 27. | Дундаж оноо | | | | | |

**Хавсралт-1**

**Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын Стандартчилал, хэмжилзүйн хэлтэст хамааралтай зорилтын биелэлтийн тайлан** /2015 оны жилийн эцсийн байдлаар/

| № | Үе шат | Стратегийн зорилт | Арга хэмжээ | Хэрэгжүү-лэх байгуул-лага | Биелэлт | Яам агентлагийн үнэлгээ | ЭЗХЯ-ны үнэлгээ | ЭЗХЯ-ны үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| БОДЛОГО | | | | | | | | |
| 19 | Нэгдүгээр үе шат (2007-2015 он) | Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай болгоно. | 45. Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх хүсэлтэй иргэдийг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах, тэдэнд техник технологийн сонголт хийхэд нь туслах, төсөл боловсруулах, шалгаруулах явцад нь зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий төвүүдийн аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд зохион ажиллуулах | СХГ | -Аймгийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг холбогдох стандарт болон шаардлагатай мэдээллээр хангах, бүтээгдэхүүнийг сорилт шинжилгээ, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтанд хамруулах чиг үүргийг хэрэгжүүлж дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>-Аймгийн хэмжээнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэж байгаа Сайншанд сумын 28 аж ахуйн нэгжийн захиалгыг үндэслэн 10 нэрийн 28 бүтээгдэхүүнийг сорилт шинжилгээнд хамруулан, 28 тохирлын гэрчилгээ олгосон.<br>-Стандартын мэдээллийн салбар сангаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэний захиалгын дагуу 40 аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс ирүүлсэн стандартын захиалгыг үндэслэн 10 нэрийн 254 стандартаар хангаж иргэдэд борлуулалт хийж арга зүйн зөвлөгөө өгч үйлчилгээ үзүүлсэн. | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | | Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд үзүүлдэг төрийн үйлчилгээг чирэгдэлгүй түргэн шуурхай болгоно. | | | “Стандарт гэж юу вэ” “Хэмжил зүй- өдөр тутмын амьдралд” зэрэг сэдвүүдээр мэдээлэл өгсөн.<br>Сайншанд суманд Аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдийн дунд “Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал” сэдвээр уулзалт, ярилцлагыг зохион байгууллаа. Уулзалтанд Хамарын хийдэд бизнес эрхэлдэг иргэд болон зочид буудал, жуулчны баазын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж,байгууллага, иргэд оролцсон байна. Тус уулзалтанд Баталгаажуулалтын шинжээч Х. Оюу-Эрдэнэ, Стандартын салбар сан хариуцсан мэргэжилтэн П. Энх-Отгон нар Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалт болон Монгол Улсад даган мөрдөж байгаа стандартын талаар мэдээлэл өгсөн.<br>Замын- Үүд сумын ЗДТГазартай хамтран тус сумын бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэж байгаа хүнсний бүтээгдэхүүний хаяг шошгыг стандартын шаардлагад нийцүүлэх зорилготой сургалтыг 2015 оны 11 дүгээр сарын 11- нд зохион байгуулав. Тус сургалтанд нийт 30 гаруй аж ахуйн нэгж, хувиараа эрхлэгч нар хамрагдаж хэрэглэгчдийг стандартын шаардлага хангасан аюулгүй цэвэр хүнс, чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хангахад бизнес эрхлэгчдэд мэдлэг олголоо. | | | |
| Үр дүн: | | 2015 оны жилийн эцсийн байдлаар Стандартчилал, хэмжилзүйн хэлтсээс жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нийт 10 нэрийн 254 стандартаар хангаж, аж ахуй нэгж, иргэний 7 нэр төрлийн 20 бүтээгдэхүүнийг сорилт шинжилгээнд хамруулж, 2 аж ахуй нэгжийн 1 бүтээгдэхүүнд тохирлын гэрчилгээ олгон холбогдох стандартын дагуу үнэлгээ хийж, зөвлөгөө өгсөн. Орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчдэд чиглэсэн 3 төрлийн сургалт мэдээллийн арга хэмжээ зохион байгуулж, 100 хүн хамрагдсанаар үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхлэх мэдлэг дээшилж, хэрэглэгчид чанартай эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээ авах боломж бүрдсэн. /Тухайн онд хамааралтай зорилтын биелэлт-80%/ | | | | | | |

**Тайлбар: Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тус хэлтэст шууд хамааралтай заалт байхгүй бөгөөд хэлтсийн чиг үүрэгт хамаарах зорилтын 1 арга хэмжээг хяналтанд авч түүний хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг тайлагнав.**

**Хавсралт-2**

**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛИЙН ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН**
**2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2015.12.05

| № | Эрхзүйн актын нэр, Агуулга Огноо Дугаар: Заалт | Хэрэг жүүлэх байгуу ллага | Хяналтанд байгаа заалтыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ | Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө | Хүчингүй болсон буюу хяналтаас хассан тухай |
|---|---|---|---|---|---|
| Бодлого | | | | | |
| 1. | МУЗГ Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай<br>2003.10.14 №222 | СХЗГ | - Заавал баталгаажуулалтанд хамрагдаж бүтээгдэхүүн үйлчилгээний газруудыг баталгаажуулалтанд хамруулах<br>- Стандартын талаар мэдээллэх | - Стандартчилал, тохирлын үнэлгээнийн тухай хуулийн 16.1-д заасны дагуу 14 сумын **284** худалдаа үйлчилгээний газруудад баталгаажуулалтын үзлэг буюу тохирлын үнэлгээг мөрдвөл зохих стандартын шаардлагын дагуу хийж, худалдаа үйлчилгээний газрын мөрдвөл зохих стандартын шаардлагыг 65-аас дээш хувийг хангаж, үйлчилгээний чанар нь тогтворжсон 284 аж ахуй нэгж, иргэнд орон тооны бус баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр **тохирлын гэрчилгээ** олгон, тохирлын тогтвортой байдлыг ханган ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.<br>- Шинээр болон шинэчлэн батлагдсан хүчингүйд тооцсон стандартын талаарх мэдээллийг estandard.mn вэб хуудас болон холбогдох байгууллагын ажилтанд цахим хэлбэрээр хүргүүлэн стандартыг сурталчлан, мэдээллэж ажилласан. | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3. | Монгол Улсын Засгийн Газрын тогтоол Стандартчилал<br>тохирлын үнэлгээний ажлыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай<br>2005.06.14 127<br>Журмын 2.12, 3.8 –д | СХЗГ | заасан экспортын бүтээгдхүүнийг баталгаажуулалтын байгууллага тохирлын гэрчилгээ олгож болно | - "Жи Пи Эф" ХХК-ын 62000 тн Мөнгөний хүдэр, "Штайн каол" ХХК-ын 120000 тн нүүрсэнд тус тус экспортын гэрчилгээ олгосон байна. | |
| 4 | МУЗГ тогтоол<br>Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах тухай<br>2009.05.14 № 143<br><br>**Нэг**.<br>Үйл ажиллагаа-ны ил тод нээлттэй байдал<br>1.1<br>1.6<br>1.7<br><br>**Хоёр.**<br>Хүний нөөцийн бодлогын ил тод байдал<br>2.4<br>2.6<br><br>**Гурав.**<br>Төсөв санхүүгийн ил тод байдал<br>3.1-3.7 | СХЗГ | Чиг үүрэгт хамаарах үйлчилгээний нээлттэй, ил тод шуурхай байдал хангагдсан байх | 1.1 Байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго тэргүүлэх чиглэл тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн үйлчилгээ үзүүлж байгаа мэргэжилтний өрөөний дугаар, бусад мэдээллийг агуулсан хаягийг шинэчлэн байрлуулж, үйл ажиллагаандаа мөрдөж буй хууль, тогтоомжийн холбогдох заалтуудыг хэлтсийн мэдээллийн самбарт тогтмол байрлуулан иргэд, үйлчлүүлэгчид тогтмол мэдээлж үйлчлэв.<br>Мөн хэлтсийн ажлын онцлог, сургалт, сурталчилгаа, арга зүйн зөвлөгөөг ажилласан сумдын байгууллага иргэдэд хүргэж ажиллав.<br>1.6, 1.7 Иргэдээс гаргасан санал, хүсэлт өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч бүртгэн, холбогдох алба нэгжүүдэд хуваарилаж хуулийн хугацаанд шийдвэрлэх арга хэмжээг шуурхай авч хэвшснээр хэлтсийн ажил үйлчилгээтэй холбоотой санал, гомдолгүй ажиллаж байна.<br>2.4 Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, үр дүнг хэлэлцэн ярилцаж, шаардлагатай арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлж ажиллав.<br>2.6 Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэл барьж ажилтнуудын үйл ажиллагааны үр дүнг нэгжийн хурлаар, дараагийн шатанд хэлтсийн дарга, нэгжийн менежер, төрийн албан хаагч хамтран хэлэлцэж үр дүнгээр нь эцсийн үнэлгээг өгч, холбогдох журамд заасны дагуу хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоод байна.<br>3.1-3.7 Хэлтсийн санхүүгийн ил тод байдлын самбарыг батлагдсан загварын дагуу шинэчилж, журамд заасан жилийн төсөв, дунд хугацааны бодлого, зорилт, стратеги, үзүүлэх үйлчилгээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, төсвийн гүйцэтгэл | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | түүнд хийсэн аудитын дүгнэлт бүхий таван дэд хэсэг, 15 үзүүлэлт бүхий мэдээллийг шинэчилж байгаа байдалд байнгын хяналт тавьж ажилласнаар мэдээллийн самбарыг байнгын ажиллагаатай болгож хэвшүүлсэн.<br>Ажил үйлчилгээний орлого болон бараа материал худалдан авах төлбөр тооцоог бэлэн бусаар хийх ажлыг байгууллагын үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, албан хаагчдад "Төсвийн тухай хууль", холбогдох санхүүгийн үйл ажиллагааны дүрэм, журмыг танилцуулан санхүүгийн зөрчилгүй ажиллах талаарх мэдээллийг хүргэж, зөрчил дутагдалгүй ажиллав.<br>Шилэн дансны тухай хууль болон "Шилэн дансны цахим хуудсанд холбогдох төсөв санхүүгийн мэдээллийг цаг тухайд нь байршуулан ажиллаж байна. | |
| 5 | Монгол Улсын Засгийн газрын тогтоол<br><br>Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах арга хэмжээний тухай<br>2013 он<br>№37<br><br>**<u>Нэг.</u>**<br>Тогтоолын 2 дугаар заалт | Төр, төсвийн бүх шатны байгууллага | Албан хэрэг хөтлөлтийн соел, ажилт-нуудын хэлбич-гийн соел дээшилсэн. | 2. "Монгол хэл бичгийн боловсролыг сайжруулах тухай "Засгийн газрын 2013 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 37-р тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Албан баримт бичиг боловсруулах арга зүй" гарын авлагаар хангаж, Стандартчилал, хэмжилзүйн газраас ирүүлсэн зөвлөмжийг төрийн албан хаагчдаар судлуулан албан хэрэг хөтлөх, бичиг баримт боловсруулахад мөрдөж ажиллав. | 100.0 |
| 6 | МУЗГ-ын тогтоол<br>Зуны цагийн хуваарьт шилжүүлэх тухай<br>№ 82 | Төр төсвийн байгууллага | | Жил бүрийн 3 дугаар сарын сүүлчийн долоо хоногийн Баасан гарагаас Бямба гарагт шилжих шөнийн 02 цагаас эхлэн 9 дүгээр сарын сүүлчийн долоо хоногийн Баасан гарагаас Бямба гарагт шилжих шөнийн 00 цаг хүртэлх хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт цагийн тооллыг шилжүүлэх тогтоолын дагуу нэг цагаар урагшлуулан өвөл, зуны цагийн хуваарьт шилжин, үйлчилгээ эхлэх цагийн хуваарийг хэвээр мөрдөж байна. | 100.0 |

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ДҮН**

| Биелэлтийн явц | | | Бүгд | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо | | | УИХ-ын тогтоол | ҮАБЗ-ийн зөвлөмж | Ерөнхийлөгчийн зарлиг | ЗГ-ын тогтоол | Ерөнхий сайдын захирамж | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл |
| Үүнээс | Хяналтанд авсан нийт зүйл заалтын тоо | | | | | 16 | | |
| | Биелсэн 100 | | | | | 16 | | |
| | Хэрэгжих шатандаа | | | | | - | | |
| | Үүний дотор | 90.0 | | | | - | | |
| | | 70.0 | | | | - | | |
| | | 50.0 | | | | - | | |
| | | 30.0 | | | | - | | |
| | | 10.0 | | | | - | | |
| | Хугацаа болоогүй | | | | | - | | |
| | Хяналтаас шилжүүлэх | | | | | - | | |
| | Тасарсан | | | | | - | | |
| | Үүнээс | Зохион байгуулалтын дутагдлаас | | | | - | | |
| | | Хөрөнгийн дутагдлаас | | | | - | | |
| Биелэлтийн дүн /хувь/ | | | | | | 100.0 | | |

## АЙМГИЙН ИТХ, ИТХТ-ИЙН ХУРЛЫН ТОГТООЛ ШИЙДВЭР, АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ, АЛБАН ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

Жилийн эцсийн байдлаар

| № | Огноо, дугаар | Эрх зүйн актын нэр, агуулга | Хэрэгжүү-лэх байгууллага | Зүйл заалтын дугаар агуулга | Хэрэгжилтийн явц | хувь |
|---|---|---|---|---|---|---|
| **Нэг. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ** | | | | | | |
| **№** | **Захирам-жийн дугаар** | **Эрх зүйн ажлын нэр** | **Хэрэг-жүүлэх байгууллага** | **Зүйл заалтын дугаар, агуулга** | **Хэрэгжилтийн явц** | |
